



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/485

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтай таван богд” Баруун бүсийн даншиг наадмын үйл ажиллагааны зардалд 1.500.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 1.500.000 төгрөг /нэг сая таван зуун мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, тээвэрлэж ирэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/485-Da

02 02569